

**ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ ШИЛЖҮҮЛЭХ, ХУГАЦААГ
СУНГАХ, ГАЗРЫН ЗОРИУЛАЛТЫГ ӨӨРЧЛӨХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Алтай хотын нутаг дэвсгэрт Газрын тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх, гэрчилгээний хугацаа сунгах, газар ашиглалтын зориулалтыг өөрчлөх шийдвэр гаргах үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Журмыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумдын газрын даамлууд үйл ажиллагаандаа мөрдөн ажиллана.

1.3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, эрхийн гэрчилгээний хугацаа сунгуулах, газар эзэмших, ашиглах зориулалтыг өөрчлөх, газрын хэмжээ нэмэгдүүлэх тухай иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумын газрын даамал хүлээн авна.

1.4. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумын газрын даамал хүсэлтийг бүртгэж, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4-т зааснаар түүнийг шийдвэрлэнэ.

1.5. Газар эзэмших эрхтэй холбоотой иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг дараах зарчмаар шийдвэрлэнэ.

1.5.1. Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай хүсэлтийг Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-д заасан үйл ажиллагаа явуулж, бичиг баримтын бүрдлийг хангуулан тухайн шатны Засаг даргад танилцуулан шийдвэр гаргуулах;

1.5.2. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах тухай хүсэлтийг Газрын тухай хуулийн 37 дугаар зүйл, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-д заасан үйл ажиллагаа явуулж, бичиг баримтын бүрдлийг хангуулсны дараа ГХБХБГазраас санал авч тухайн шатны Засаг даргад танилцуулж шийдвэр гаргуулах;

1.5.3. Газар эзэмших, ашиглах зориулалтыг өөрчлүүлэх тухай хүсэлтийг Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-д заасан үйл ажиллагаа явуулж, бичиг баримтын бүрдлийг ханган шийдвэрийн төслийг Аймгийн

газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, сумын даамал тухайн шатны Засаг даргад танилцуулж шийдвэр гаргуулах;

1.6. Эзэмшил газрынхаа хэмжээг тухайн байршилдаа нэмэгдүүлэх тухай хүсэлтийг Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасныг баримтлан нэмэгдүүлэхээр хүсэлт гаргасан газрын хэмжээгээр мөн хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д заасан дуудлага худалдааны анхны үнийг 20-иос дээш дахин нэмэгдүүлсэн үнийг төлүүлсний дараа тухайн шатны Засаг дарга шийдвэрлэнэ.

1.7. Иргэн өмчийн газраа бусдад ашиглуулах, эзэмшүүлэх, газар өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх, барьцаалахтай холбоотой харилцааг Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 24 дүгээр зүйл, 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.1.3, 29 дүгээр зүйл, Иргэний хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн холбогдох бусад заалтад заасны дагуу зохицуулна.

Хоёр. Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай шийдвэр гаргах үйл ажиллагаа

2.1. Газар эзэмших эрхийн гэрчилгээ шилжүүлэх хүсэлтийг Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумын газрын даамал хүлээн авна.

2.2. Эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай хүсэлтийг хүлээн авахдаа Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2.2-т заасан нотолгоог гэрээ, эсхүл хүсэлтэд тусгах бөгөөд уг бичиг баримтад газрын эрх олгогдох үед эрх шилжүүлэгч талд хүлээлгэсэн эрх, үүрэг, түүнийг хангах аргыг газар эзэмших эрхийн гэрчилгээний хамт гэрчилгээг шилжүүлэн авч буй тал залгамжлан авахыг хүлээн зөвшөөрч байгааг тусгасан байна.

2.3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авч байгаа этгээдийн гэрчилгээний хугацааг гэрчилгээ шилжүүлэн авсан өдрөөс эрх шилжүүлэгчид анх олгосон гэрчилгээний хугацаа дуусгавар болох хүртэлх хугацаагаар тогтоож шийдвэрийн төслийг бэлдэнэ.

2.4. Газар эзэмшигч газраа бүхэлд нь шилжүүлж байгаа тохиолдолд газрын зориулалт, хэмжээг, газрынхаа зарим хэсгийг шилжүүлж байгаа тохиолдолд газрын зориулалтыг өөрчлөхгүй.

2.5. Газар эзэмших эрхийн гэрчилгээ шилжүүлэх хүсэлт болон түүнд хавсаргасан бичиг баримт Газрын тухай хууль болон газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээнд заасан шаардлагыг хангасан тохиолдолд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумын газрын даамал ажлын 15 хоногт багтаан газар эзэмших эрхийн гэрчилгээ шилжүүлэх талаар гаргах тухайн шатны Засаг даргын шийдвэрийн төслийг бэлдэж танилцуулан шийдвэр гаргуулна.

2.6. Тухайн шатны Засаг даргын шийдвэрийг үндэслэн аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумын газрын даамал газрын улсын бүртгэлд газрын эрх шилжсэнийг бүртгэнэ.

2.7. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4-т заасан эзэмших эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэхэд төлөх хураамжийг төлсөн

тохиолдолд шилжүүлэн авч буй этгээдэд газар эзэмших эрхийн гэрчилгээг шинээр олгож, газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэхгүйгээр өмнөх эзэмшигчтэй хийсэн гэрээнд хавсралтаар зөвхөн газар эзэмшигчийн нэр өөрчлөгдсөн тухай нэмэлт өөрчлөлт оруулна.

Гурав. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах тухай шийдвэр гаргах үйл ажиллагаа

3.1. Алтай хотын болон сумын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө, газар дээрх үл хөдлөх хөрөнгө, барилга байгууламжийн ашиглалтын зориулалт, хийц, газрын гэрээний үүргийн гүйцэтгэлийг үндэслэл болгон газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 40 хүртэл жил, ашиглах эрхийн гэрчилгээний хугацааг 5 хүртэл жилээр сунгах тухай шийдвэрийг тухайн шатны Засаг дарга гаргана.

3.2. Газрын эрхийн гэрчилгээг сунгах хугацааг тодорхойлохдоо дараах зарчмыг баримтална:

3.2.1. Барилга, байгууламж барих зориулалтаар газрын эрх авч гэрээ хийсэн боловч захиргааны байгууллага болон бусдын хууль бус үйлдлээс шалтгаалан газар эзэмших, ашиглах гэрээ хийснээс хойш 2 жилийн хугацаанд барилга, байгууламж барьж эхлээгүй газар эзэмшигч, ашиглагчийн гэрчилгээний хугацааг дээр дурьдсан шалтгаан үргэлжилсэн хугацаагаар 1 удаа сунгах;

3.2.2. Гэрээнд заасан хугацаанд барилга байгууламжаа барьж ашиглалтад өгсөн этгээдэд барилга байгууламжийн ашиглалтын зориулалт, хийц, газрын гэрээний үүргийн гүйцэтгэлийг үндэслэл болгон тухайн газрыг үргэлжлүүлэн хуульд заасан хугацаагаар энэ журамд заасан зарчмыг баримтлан сунгах;

3.2.3. Тухайн газрыг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, үүргийн болон нутаг дэвсгэрийн бүсчлэлд тусгагдсанаас өөр зориулалтаар болон уурхайн эдэлбэрийн зориулалтаар эзэмшиж буй газар эзэмшигчийн гэрчилгээний хугацааг 5 хүртэл жилээр

3.2.4. Тухайн газрыг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, үүргийн болон нутаг дэвсгэрийн бүсчлэлд тусгагдсан зориулалтаар ашиглаж байгаа, 10 жилээс дээш насжилттай, 1-3 давхар барилга бүхий болон нефтийн бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц, бөөний худалдааны зах, төвүүдийн газар эзэмшигчийн гэрчилгээний хугацааг 5-10 жилээр;

3.2.5. Тухайн газрыг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, үүргийн болон нутаг дэвсгэрийн бүсчлэлд тусгагдсан зориулалтаар ашиглаж байгаа, доороо үйлчилгээтэй орон сууцны 5-12 давхар барилга, амины орон сууцны барилга, худалдаа, бүх төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ, шашин, сүм хийд, аж ахуйн бусад зориулалтаар газар эзэмшигчийн гэрчилгээний хугацааг 10-15 жилээр;

3.2.6. Тухайн газрыг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, үүргийн болон нутаг дэвсгэрийн бүсчлэл тусгагдсан зориулалтаар ашиглаж байгаа, зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, хүүхдийн байгууллага, төрийн байгууллагын, хотын нийтийн тээвэр, дулаан, холбоо, эрчим

хүчний хангамж, төмөр зам, нисэх онгоцны буудлын зориулалттай газрын гэрчилгээний хугацааг 15-20 жилээр;

3.2.7. Алтай хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу шинээр баригдсан иргэний, үйлдвэрлэлийн болон хөдөө аж ахуйн зориулалтаар баригдсан барилга, байгууламжийн газар эзэмшигчийн гэрчилгээний хугацааг 20-40 жилээр сунгаж шийдвэр гаргана.

3.3. Эрхийн гэрчилгээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө газар эзэмшигч, ашиглагч нь хугацаа сунгуулах хүсэлтээ гаргаагүй тохиолдолд өмнөх газрын эрх дуусгавар болсноос хойшхи хугацаанд газрыг зөвшөөрөлгүй ашигласан гэж үзэж Газрын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.11-т заасан захиргааны хариуцлагыг ногдуулж, торгуулийг төлсний дараа гэрчилгээний хугацаа сунгаж шийдвэр гаргана.

3.4. Газрын эрхийн гэрчилгээний хугацаа сунгуулах хүсэлтийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумын газрын даамал хүлээн авна.

3.5. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумын газрын даамал газрын эрхийн гэрчилгээний хугацаа сунгуулах хүсэлтийг Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т заасны дагуу газар эзэмшигч, ашиглагч эрхийн гэрчилгээ эзэмших нөхцөлийг хангасан эсэхийг хянаж газрын гэрээний үүргийн биелэлтийг дүгнэнэ.

3.6. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумын газрын даамал нь газар эзэмшигч, ашиглагч эрхийн гэрчилгээ эзэмших нөхцөлийг хангасан эсэхийг хянаж тогтооходоо газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээний үүргийн биелэлтийг зүйл тус бүрээр дүгнэж акт үйлдэн шинэчлэн байгуулах гэрээнд хавсаргана.

3.7. Газрын эрхийн гэрчилгээний хугацааг сунгахдаа газрын зориулалтыг газар зохион байгуулалтын болон хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан газар ашиглалтын зориулалтаар тодорхойлон өөрчлөнө.

3.8. Алтай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд, нийтийн эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа бүтээн байгуулалт хийгдэх тохиолдолд тухайн иргэн, ААНэгжийн газрын байршлыг шилжүүлж олгож болно. Төрийн үйл ажиллагаанд саад учруулсан иргэн хуулийн этгээдийн эзэмшиж, ашиглаж буй газрын гэрчилгээ, гэрээг тухайн шатны Засаг дарга цуцлана.

3.9. ГХБХБГазар ажлын 5 хоногт багтаан саналаа бичгээр гаргана. Дурьдсан хугацаанд санал ирүүлээгүй тохиолдолд зөвшөөрсөн санал өгсөнд тооцно.

3.10. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумын газрын даамал гэрээний үүргийн биелэлтийг дүгнэсэн акт, Аймгийн Ерөнхий архитекторын саналыг тусган тухайн шатны Засаг даргын гаргах шийдвэрийн төслийг бэлдэж танилцуулна.

3.11. Тухайн шатны Засаг дарга газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний хугацааг сунгах эсэх талаар шийдвэр гаргана.

3.12. Газар эзэмшигч, ашиглагч гэрээний үүргийн биелэлтийг хангаагүй нь актаар тогтоогдсон тохиолдолд захиргааны байгууллагаас гэрээний үүргийн биелэлтийг хангах 30 хоногийн хугацаа тогтоож зөрчлийг арилгуулна.

3.13. Тогтоосон хугацаанд гэрээний үүргийн биелэлтийг хангаагүй тохиолдолд үүргийн биелэлт хангах хүртэл гэрчилгээний хугацааг сунгахгүй бөгөөд зөрчлийг арилгасны дараа газрын гэрчилгээний хугацаа сунгахдаа энэ журмын 3.3-т заасан арга хэмжээ авна.

3.14. Тухайн шатны Засаг даргын шийдвэрийг үндэслэн Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумын газрын даамал газрын улсын бүртгэлд газар эзэмших гэрчилгээний хугацаа сунгагдсан талаарх бүртгэлийг хийнэ.

4. Газар ашиглалтын зориулалт өөрчлөх тухай шийдвэр гаргах үйл ажиллагаа

4.1. Газар эзэмшигч, ашиглагчийн газар ашиглалтын зориулалтыг дараах үндэслэлээр тодорхойлон өөрчилж болно.

4.1.1. Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан газар ашиглалтын зориулалт;

4.1.2. Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд газар ашиглалтын зориулалт тусгагдсан байдал /үүргийн бүсчлэл/;

4.1.3. Хүсэлт гаргагч аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэгдсэн үйл ажиллагааны чиглэл;

4.2. Тухайн газар дээр 3-аас дээш төрлийн үйл ажиллагаа явуулж буй тохиолдолд газар ашиглалтын зориулалтыг тогтоохдоо эзэмшил газрын талбайн хэмжээнд хамгийн их хувийг эзэлсэн газарт явагдаж байгаа үйл ажиллагааны төрлөөс эхлэн 2-оос илүүгүй газар ашиглалтын зориулалтыг тухайн шатны Засаг даргын шийдвэрт тусгаж, эрхийн гэрчилгээнд бичнэ.

4.3. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумын газрын даамал нь газар эзэмших гэрээний үүргийн биелэлтийг хангаж ажилласныг актаар, журмын 4.1-д заасан үндэслэлийн дагуу газар ашиглалтын зориулалтыг ажлын 5 хоногийн дотор тогтоож газар ашиглалтын зориулалтыг өөрчлөх эсвэл цуцлах санал гаргана.

4.4. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумын газрын даамал гэрээний үүргийн биелэлтийг дүгнэсэн акт, саналыг тусган тухайн шатны Засаг даргын гаргах шийдвэрийн төслийг бэлтгэн тухайн шатны Засаг даргад танилцуулж шийдвэр гаргуулна.

4.5. Тухайн шатны Засаг даргын шийдвэрийг үндэслэн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумын газрын даамал газрын улсын бүртгэлд газар

ашиглалтын зориулалт өөрчилсөн эсвэл цуцалсан талаарх бүртгэлийг хийж, зориулалт өөрчлөгдсөн тохиолдолд гэрээг шинэчлэн байгуулж гэрчилгээг шинээр олгоно.

Тав. Газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээнд шаардлагатай гэж үзсэн бусад зүйлийг тусгах

5.1. Газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээг Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2003 оны 157 дугаар тушаалын хавсралтаар баталсан загварын дагуу байгуулахдаа Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.6.11-д заасан гэрээнд тусгах шаардлагатай гэж үзсэн бусад зүйлийг гэрээ тус бүрт тусгайлан зааж оруулсан байна.

5.2. “Гэрээнд тусгах шаардлагатай гэж үзсэн бусад зүйл” гэдэгт газрын байршил, төлөвлөлт, зориулалт, газар эзэмших, ашиглах гэрчилгээний хугацаа, газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх тохиолдол, газар ашиглалтын онцлогоос шалтгаалан гэрээгээр нэмж хүлээлгэх нөхцөл, болзлыг ойлгоно.

5.3. Газар эзэмшигч, ашиглагчид гэрээгээр нэмж хүлээлгэх нөхцөл, болзлыг гэрээ байгуулах эрх бүхий этгээд зохих шийдвэр, зайлшгүй нөхцөлийг үндэслэн гэрээнд тусгаж оруулна.

5.4. Шаардлагатай тохиолдолд гэрээгээр нэмж хүлээлгэх нөхцөл, болзлыг журам батлагдахаас өмнө байгуулсан газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээнд тусгаж, гэрээг шинэчлэн байгуулж болно.

Зургаа. Хориглох зүйл

6.1. Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, эрхийн гэрчилгээний хугацаа сунгуулах, газар эзэмших, ашиглах зориулалтыг өөрчлөх, газрын хэмжээ нэмэгдүүлэх хүсэлт шийдвэрлэхэд дараах үйл ажиллагааг хориглоно.

6.1.1. Газрын тухай хуулийн 37, 38 дугаар зүйлийн холбогдох заалтуудад заасан бичиг баримтын бүрдэл хангаагүй хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх,

6.1.2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, эрхийн гэрчилгээний хугацаа сунгуулах, газар эзэмших, ашиглах зориулалтыг өөрчлөх, газрын хэмжээ нэмэгдүүлэх хүсэлтийг газар эзэмших, ашиглах гэрээний үүргийн биелэлтийг дүгнэлгүйгээр, журмын 3.3, 3.12, 3.13-т заасан зөрчил арилгуулах арга хэмжээ авалгүйгээр шийдвэрлэх,

6.1.3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэхдээ эрхийн гэрчилгээний хугацааг анх олгогдсон гэрчилгээний хугацаанаас илүү хугацаагаар сунгах, газар эзэмших, ашиглах зориулалтыг өөрчлөх, талбайн хэмжээг нэмэгдүүлэх, багасгах,

6.1.4. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгахдаа журмын 3.2-т зааснаас өөр үндэслэл, хугацаагаар гэрчилгээ сунгах хугацааг тогтоох.

6.1.5. Газар ашиглалтын зориулалтыг журмын 4.1.1-4.1.3-т зааснаас бусад үндэслэлээр өөрчлөх,

6.1.6. Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, эрхийн гэрчилгээний хугацаа сунгуулах, газар эзэмших, ашиглах зориулалтыг өөрчлөх, газрын хэмжээ нэмэгдүүлэх хүсэлтийг шийдвэрлэхдээ Газрын тухай хууль болон энэ журамд заасан хугацааг хэтрүүлэх.

6.1.7. Хүсэлтийг шийдвэрлэхдээ бусад хууль тогтоомж зөрчих,

Долоо. Хариуцлага

7.1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага гаргасан шийдвэрийнхээ хууль зүйн үндэслэл, хариуцлагыг бүрэн хүлээнэ.

7.2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, эрхийн гэрчилгээний хугацаа сунгуулах, газар эзэмших, ашиглах зориулалтыг өөрчлөх, газрын хэмжээ нэмэгдүүлэх талаарх Засаг даргын хууль бус шийдвэрийг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Газрын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д заасныг үндэслэн дараах тохиолдолд Засаг дарга өөрөө буюу түүний дээд шатны Засаг дарга хүчингүй болгоно.

7.2.1. Тухайн шийдвэр нь газрын тухай хууль тогтоомжийг зөрчсөн нь тогтоогдсон,

7.2.2. Тухайн шийдвэр нь газар эзэмшигч, ашиглагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчсөн нь тогтоогдсон.

7.3. Журмын 7.2.1, 7.2.2-т заасан Засаг даргын шийдвэр Газрын тухай хууль тогтоомж, газар эзэмшигч, ашиглагчийн хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн эсэхийг тогтооход Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т заасан байгууллага, албан тушаалтны гаргасан санал, дүгнэлтийг үндэслэл болгоно.

7.4. Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасан журмаар сахилгын шийтгэл ногдуулна.

7.5. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хаагч, албан тушаалтан, сумын газрын даамал албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас тухайн байгууллага нь захиргааны хариуцлага хүлээсэн бол зөрчил гаргасан албан хаагч, албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулна.

7.6. Журмын 3.6, 4.3-т заасан гэрээ дүгнэх явцад газар эзэмшигч, ашиглагч газрын тухай болон хот байгуулалтын тухай хууль тогтоомж зөрчсөн нь тогтоогдсон тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтан Газрын тухай хууль, Хот байгуулалтын тухай хуульд заасан хариуцлага ногдуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хандаж болно.

7.6.1. Зохих зөвшөөрөлгүйгээр газар дээр барилга байгууламж барьсан эсхүл бусад хэлбэрээр түүнийг дур мэдэн эзэмшсэн, ашигласан бол Эрүүгийн хуулийн 153 дугаар зүйлд заасан бусдын өмчийг гэмтээсэн гэсэн үндэслэлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тухайн шатны Засаг дарга, аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумын газрын даамал эрх бүхий байгууллагад хандана.

7.6.2. Газар эзэмших, ашиглах, өмчлөх болон барилга байгууламж барих явцдаа нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг эвдсэн, гэмтээсэн этгээдэд зөрчлийн шинж байдлаас хамааран Захиргааны хариуцлагын тухай хуулийн 38 дугаар зүйлийг үндэслэн захиргааны хариуцлага хүлээлгэхээр тухайн шатны Засаг дарга, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумын газрын даамал эрх бүхий байгууллагад хандана.

7.6.3. Төрийн өмчийн газарт барилга байгууламж барихаар газрын эрх олгогдсон боловч зохих зөвшөөрөлгүйгээр барилга угсралтын ажил эхлүүлсэн, гүйцэтгэсэн этгээдэд Захиргааны хариуцлагын тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан захиргааны хариуцлага хүлээлгэхээр тухайн шатны Засаг дарга, эсхүл аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумын газрын даамал эрх бүхий байгууллага, этгээдэд хандана.

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ ТҮҮНИЙ
УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ

29 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын нийтлэг бүрэн эрх

29.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

29.3. Засаг даргын захирамж хууль тогтоомжид нийцээгүй бол өөрөө, эсхүл сум, дүүргийн Засаг даргын захирамжийг аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжийг Ерөнхий сайд тус тус өөрчлөх буюу хүчингүй болгоно.

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ

33 дугаар зүйл. Газар эзэмшүүлэх шийдвэр гаргах

33.1. Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг дараахь журмыг баримтлан шийдвэрлэнэ:

33.1.2. Энэ хуулийн 33.1.1-д зааснаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ. Төсөл шалгаруулах, дуудлага худалдаа явуулах журмыг Засгийн газар тогтооно.

34 дүгээр зүйл. Газар эзэмших гэрээ, түүнийг байгуулах журам

34.1. Энэ хуулийн 33.1-д заасан газар эзэмшүүлэх тухай шийдвэрийг үндэслэн сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын алба тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, улсын бүртгэлд бүртгэнэ.

34.6. Газар эзэмших гэрээнд дараахь зүйлийг тусгана:

34.6.11. Шаардлагатай гэж үзсэн бусад зүйл.

36 дугаар зүйл. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны үнэ, үйлчилгээний хураамж

36.1. Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан аргачлалын дагуу тухайн шатны Засаг дарга тогтооно.

37 дугаар зүйл. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгах

37.1. Эрхийн гэрчилгээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө эзэмшигч нь хугацаа сунгуулах тухай хүсэлтээ тухайн шатны Засаг даргад гаргах бөгөөд дараахь баримт бичгүүдийг хавсаргана:

37.1.1. Газар эзэмших эрхийн гэрчилгээ;

37.1.2. Газрын төлбөрийг төлсөн тухай баримт;

37.1.3. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр гарсан дүгнэлтийг хэрэгжүүлсэн талаархи тодорхойлолт

38 дугаар зүйл. Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх

38.1. Газар эзэмших эрхийн гэрчилгээг хуулиар зөвшөөрсөн хэлбэрээр бусдад шилжүүлж, барьцаалж болно. Эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, барьцаалах үйл ажиллагаа нь зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд явагдана.

38.2. Эрхийн гэрчилгээг шилжүүлэх хүсэлтийг талууд гаргах бөгөөд дараахь баримт бичгийг хавсаргана:

38.2.1. Нотариатчаар гэрчлүүлсэн гэрээ;

38.2.2. Эрхийн гэрчилгээг шилжүүлэн авч байгаа этгээд нь уг эрхийн гэрчилгээг шилжүүлэн авснаар үүсэх эрх, үүргийг бүрэн хүлээн зөвшөөрч байгаа тухай нотолгоо;

38.2.3. Хураамж төлсөн тухай баримт.

38.3. Эрхийн гэрчилгээ шилжүүлэх тухай хүсэлтийг тухайн шатны Засаг дарга хүлээн авч дараахь зүйлүүдийг тодруулна:

38.3.1. Энэ хуулийн 38.2-т заасан шаардлагыг хангасан эсэх;

38.3.2. Шилжүүлэхийг хүссэн эрхийн гэрчилгээ нь хүчин төгөлдөр эсэх;

38.3.3. Эрхийн гэрчилгээг шилжүүлэн авч байгаа этгээд нь уг эрхийн гэрчилгээг эзэмших эрхтэй эсэх.

38.4. Эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор тухайн шатны Засаг дарга шийдвэр гаргана. Уг шийдвэрийг үндэслэн сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын албанд бүртгүүлснээр эрхийн гэрчилгээг шилжүүлсэн нь хүчин төгөлдөр болно.

38.5. Газар эзэмшигч нь газар эзэмших эрхээ Иргэний хуульд нийцүүлэн барьцаалж болох бөгөөд энэ тохиолдолд сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын албанд бүртгүүлж, эрхийн гэрчилгээнд барьцаалсан тухай тэмдэглэл хийлгэнэ.

57 дугаар зүйл. Газрын нэгдмэл санд төрийн хяналт тавих

57.1. Газрын нэгдмэл санг эзэмших, ашиглах, хамгаалах болон газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд Засгийн газар, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчид, Засаг дарга хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ дагуу хяналт тавина.

57.2. Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих мэргэжлийн хяналтыг хууль тогтоомжийн дагуу эрх олгогдсон байгаль орчны хяналтын газар болон

ургамал, хорио цээр, эрүүл ахуй, геологи, уул уурхайн зэрэг мэргэжлийн байгууллагууд хэрэгжүүлнэ.

61 дүгээр зүйл. Хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, үйлдлийг таслан зогсоох

61.1. Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан өөрийн шийдвэр, үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ газрын тухай хууль тогтоомж, газар эзэмшигч, ашиглагчийн хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол уг байгууллага, албан тушаалтан өөрөө буюу түүний дээд шатны байгууллага, албан тушаалтан, эсхүл шүүх уг хууль бус шийдвэрийг хүчингүй болгож, үйлдлийг таслан зогсооно.

63 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

63.1. Газрын тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол байгаль орчны хяналтын улсын байцаагч дор дурдсан захиргааны шийтгэл оногдуулна:

63.1.11. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр газар ашигласан бол иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин, байгууллага, аж ахуйн нэгжийг дөчөөс наяд дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хохирлыг нөхөн төлүүлэх;

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД ГАЗАР ӨМЧЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ

24 дүгээр зүйл. Иргэний газар өмчлөх эрхийн болон газар өмчлөх эрхтэй холбогдсон хөдөлгөөний бүртгэл

24.1. Иргэний газар өмчлөх эрхтэй холбогдсон хөдөлгөөний бүртгэлийг Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу хөтөлнө.

24.2. Иргэний хувийн өмчийн газрын заагийг газар дээр нь тогтоох, тэмдэглэх, заагийн өөрчлөлтийг бүртгэлд тусгах, хянах үйл ажиллагааг сумын газрын даамал, дүүргийн газрын алба тус тус хариуцан гүйцэтгэнэ.

26 дугаар зүйл. Иргэний газар өмчлөхтэй холбогдсон харилцааг зохицуулах

26.1. Иргэний газар өмчлөхтэй холбогдсон нийтлэг харилцааг Иргэний хууль, онцлог харилцааг энэ хуулиар зохицуулна.

27 дугаар зүйл. Газар өмчлөгч иргэний эрх, үүрэг

27.1. Газар өмчлөгч иргэн дараахь эрхтэй:

27.1.3. Өмчийнхөө газрыг зохих журмын дагуу иргэнд худалдах, арилжих, өвлүүлэх, бэлэглэх зэргээр захиран зарцуулах;

29 дүгээр зүйл. Иргэн өмчийн газраа бусдад эзэмшүүлэх, ашиглуулах

29.1. Иргэн өмчийн газраа зориулалтаар нь, тодорхой хугацаагаар сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрлөөр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно.

29.2. Иргэн өмчийн газраа бусдад эзэмшүүлэх, ашиглуулах зөвшөөрөл авах тухай хүсэлтээ сум, дүүргийн Засаг даргад бичгээр гаргана.

29.3. Энэ хуулийн 29.2-т заасан хүсэлтэд өмчийн газраа бусдад эзэмшүүлэх, ашиглуулах зориулалт, хугацаа зэргийг зааж, 18 нас хүрсэн гэр бүлийн гишүүн бүр буюу бусад хамтран дундаа эзэмшигч бүр гарын үсэг зурна.

29.4. Энэ хуулийн 29.2-т заасан хүсэлтэд иргэний өмчийн газраа эзэмшүүлэх, ашиглуулах талаар тухайн газрыг эзэмших, ашиглах этгээдтэй байгуулсан, нотариатчаар гэрчлүүлсэн гэрээний эх хувийг хавсаргана.

29.5. Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 29.2-т заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор зөвшөөрөл өгөх эсэхийг шийдвэрлэнэ.

29.6. Иргэний өмчийн газрыг эзэмших, ашиглах этгээд нь энэ хууль, Газрын тухай, Газрын төлбөрийн тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хууль зөрчиж байсан бол, түүнчлэн тухайн газарт хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харш үйл ажиллагаа явуулж болзошгүй нь тогтоогдвол сум, дүүргийн Засаг дарга зөвшөөрөл олгохоос татгалзаж болно.

29.7. Иргэний өмчийн газрыг эзэмшиж, ашиглаж буй этгээд нь энэ хууль, Газрын тухай, Газрын төлбөрийн тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай, Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийг зөрчсөн, түүнчлэн тухайн газарт хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харш үйл ажиллагаа явуулбал сум, дүүргийн Засаг дарга олгосон зөвшөөрлөө хүчингүй болгоно.

29.8. Сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрөл олгохтой холбогдсон гомдлыг шүүх шийдвэрлэнэ.

29.9. Иргэний өмчийн газрыг гэрээний үндсэн дээр хөлсөлж, түрээсэлж байгаа гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүн уг газрыг бусдад дамжуулан хөлслөх, дамжуулан түрээслэхийг хориглоно.

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ

39 дүгээр зүйл. Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах зөвшөөрөл олгох, газрын хэвлийг олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

39.1.4. Аж ахуйн нэгж, байгууллага газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэхэд нийслэлд 70 000 төгрөг, аймгийн төвийн сум, нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт 20 000 төгрөг, бусад суманд 10 000 төгрөг;

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

153 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх

153.1. Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгасан буюу гэмтээсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

153.2. Энэ гэмт хэргийг галдан шатаах буюу нийтэд аюултай бусад аргаар үйлдсэн, эсхүл энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ

10 дугаар зүйл. Захиргааны хариуцлага хүлээлгэх харьяалал

Захиргааны хариуцлага хүлээлгэхээр энэ хуульд заасан зөрчлийг эрх бүхий албан тушаалтан дараахь харьяаллаар хянан шийдвэрлэнэ:

4/ Хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон улсын байцаагч энэ хуулийн 25, 25¹, 25², 26, 26¹, 27, 28¹, 30⁴ дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг, 34¹, 38¹, 42, 43, 43¹, 44, 46, 46¹, 47, 50, 52 дугаар зүйлд заасан зөрчил;

25 дугаар зүйл. Хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих

1. Согтууруулах ундааны зүйл уусан үедээ тээврийн хэрэгсэл жолоодож явсан, эсхүл согтууруулах ундааны зүйл уусан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 6 сараас хоёр жил хүртэл хугацаагаар хасах шийтгэл ногдуулна.

2. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан, эсхүл тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй этгээд тээврийн хэрэгсэл жолоодсон бол 25000-50000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

3. Ашиглахыг хориглосон, гэмтэлтэй буюу зохих зөвшөөрөлгүйгээр өөрчлөн тоноглосон тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон, эсхүл дээрхи тээврийн хэрэгслийг замд гаргах зөвшөөрөл олгосон, түүнчлэн тогтоосон журмын дагуу бүртгүүлээгүй, техникийн улсын үзлэгт хүндэтгэх шалтгаангүйгээр оруулаагүй, зам тээврийн осолд орсон тээврийн хэрэгслийг зохих байгууллагад мэдэгдэлгүйгээр засварт оруулсан бол 5000-25000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

4. Явган болон унадаг дугуй, ердийн хөсгөөр зорчигч этгээд хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн бол 100-8000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

5. Жолооч болон тээврийн байгууллагын ажилтан хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 1000-10000 төгрөгөөр торгох, эсхүл тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасах шийтгэл ногдуулна.

6. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй этгээд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон тохиолдолд 7-30 хоног баривчлах шийтгэл ногдуулна.

7. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол иргэнийг 5000-30000, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-200000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

25¹ дүгээр зүйл. Гал түймрээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, журам зөрчих

Гал түймэртэй тэмцэх байгууллагын эрх бүхий ажилтны хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн, биелүүлэхээс зайлсхийсэн, гал түймрээс урьдчилан сэргийлэх зориулалттай барилгын хийц, бүтээц болон орон сууцны агааржуулах төхөөрөмжийг дур мэдэн өөрчилсөн, галын автомат дохиолол, гал унтраах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг санаатайгаар гэмтээсэн, тоносон, түүнчлэн шатах тослох

материал, тэсэрч дэлбэрэх бодисыг зориулалтын бус газар хадгалах, ой, хээрийн түймэр тавих зэргээр гал түймрээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас тогтоосон журмыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчил гаргасан иргэнийг 1000-50000 төгрөгөөр, албан тушаалтныг 30000-60000 төгрөгөөр, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-250000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

25² дугаар зүйл. Тээвэр ашиглалт болон замын байгууламж ашиглах журам зөрчих

26 дугаар зүйл. Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих

1. Галт тэрэгний хөдөлгөөнийг саатуулж болох зүйлсийг төмөр зам дээр тавих, мал, ердийн хөсөг болон тээврийн хэрэгслийг төмөр зам дээгүүр гарцгүй газраар гаргах, төмөр замын хориотой бүсэд зөвшөөрөлгүй нэвтрэх, мал бүхий иргэд малаа хариулгагүй орхисноос төмөр замын хориг хашаанд оруулах, түүнчлэн галт тэргийг дур мэдэн зогсоох, дээвэр, гишгүүр дээр зорчих, хөдөлгөөн дунд буух, суух зэргээр төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 500-25000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

2. Төмөр замын төхөөрөмж, хамгаалалтын тор, хаалт, галт тэрэгний болон хөдлөх бүрэлдэхүүний эд анги, суудлын галт тэрэгний тоноглолыг эвдэж, гэмтээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 5000-50000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

3. Галт тэргээр тасалбаргүй зорчсон бол 200-40000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

26¹ дүгээр зүйл. Нислэгийн аюулгүй байдлыг хангах журам зөрчих

1. Агаарын хөлгөөр тасалбаргүй зорчих, түүнчлэн нислэгийн хэвийн ажиллагааг хангах үүднээс тавьж буй агаарын хөлгийн даргын хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй байх зэргээр агаарын хөлгөөр зорчих журам болон олон улсын нислэгийн журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 50000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

2. Нислэг үйлдэх талбай буюу аэродромын хамгаалалтын бүсэд зөвшөөрөлгүй нэвтэрсэн, мал оруулсан бол 15000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

27 дугаар зүйл. Иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспорт, иргэний гэр бүлийн байдлын баримт бичиг олгох, эзэмших, хадгалах, шиджин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам зөрчих

Монгол Улсын Иргэний үнэмлэх болон үндэсний гадаад паспорт иргэний гэр бүлийн байдлын баримт бичиг олгох, эзэмших, хадгалах, шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол иргэнийг 40000, албан тушаалтныг 60000 хүртэлх төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

28¹ дүгээр зүйл. Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах журам зөрчих

1. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх журмыг зөрчиж, эрхийг нь хууль бусаар хязгаарласан бол 50000-150000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

2. Гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлахад зөвшөөрөл авах журмыг зөрчсөн буюу хуурамч баримт бичиг бүрдүүлж зөвшөөрөл авсан бол 100000-250000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

3. Гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлахад зөвшөөрөл олгох журмыг зөрчсөн бол 100000-250000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

30⁴ дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтны хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх

3. Шийдвэр биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн, хуурамч гэрээ хийж, эд хөрөнгөө бусдад шилжүүлсэн, нуусан, битүүмжилсэн эд хөрөнгийг санаатайгаар үрэгдүүлсэн бол 5000-10000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

4. Төлбөр төлөгчийн цалин орлогоос суутгал хийгээгүй, дутуу суутгасан, суутгасан мөнгийг хуульд заасан хугацаанд олгоогүй буюу шилжүүлээгүй, төлбөр, тэтгэлэг төлөгчийг ажлаас халагдсаныг мэдэгдээгүй бол 1000-15000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна

34¹ дүгээр зүйл. Архив, албан хэрэг хөтлөлтийн журам зөрчих

Архив, албан хэрэг хөтлөлтийн журам зөрчсөн бол зөрчил гаргасан иргэнийг 1000-30000, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-80000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

38 дугаар зүйл. Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө эвдэх, гэмтээх

Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг эвдсэн, гэмтээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 1500-15000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

38¹ дугаар зүйл. Барилга, хот байгуулалтын журам зөрчих

1. Зохих зөвшөөрөлгүйгээр барилга угсралтын болон барилгын зураг, төсөл зохиох ажил гүйцэтгэх, барилгын хийц, эдлэл, материал үйлдвэрлэх явцад барилга, байгууламжийн бат, бэх, тогтворт буюу найдвартай чанарыг алдагдуулах зэргээр барилга, хот байгуулалтын журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчил гаргасан иргэнийг 40000 хүртэл, албан тушаалтныг 1000-50000, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-250000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

2. Барилгын ажил гүйцэтгэсний дараа зам, талбай, шугам сүлжээ болон бусад байгууламжийг анх байсан байдлаар нь сэргээн засаагүй, эсхүл дутуу буюу чанаргүй гүйцэтгэсэн бол зөрчил гаргасан иргэнийг 30000 хүртэл, албан тушаалтныг 40000 хүртэл, байгууллага, аж ахуйн нэгжийг 150000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

42 дугаар зүйл. Худалдаа, үйлчилгээний журам зөрчих

1. Хориглосон үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хууль бусаар олсон орлого буюу эд зүйлийг хурааж, зөрчил

гаргасан иргэнийг 10000-50000, байгууллага, аж ахуйн нэгжийг 80000-250000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

2. Зохих зөвшөөрөлгүйгээр худалдаа, үйлчилгээ явуулсан бол хууль бусаар олсон орлого буюу эд зүйлийг хурааж, зөрчил гаргасан иргэнийг 500-20000, байгууллага, аж ахуйн нэгжийг 60000-150000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

3. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр хориглосон газар, цэгт худалдаа, үйлчилгээ явуулсан бол хууль бусаар олсон орлого буюу эд зүйлийг хурааж, зөрчил гаргасан иргэнийг 1000-20000, байгууллага, аж ахуйн нэгжийг 80000-200000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

43 дугаар зүйл. Тайлан, мэдээ, тооллого, бүртгэлийн журам зөрчих

1. Хүн ам, эд хөрөнгө, мал, тэжээвэр амьтан, аж ахуйн нэгжийн улсын тооллого явуулах, бүртгэх ажлаас зайлсхийсэн, эсхүл тооллого, судалгаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй, түүнчлэн эд хөрөнгө, мал, тэжээвэр амьтныг тооллогоос нуун дарагдуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол холбогдох албан тушаалтан, иргэнийг 20000-100000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

2. Хууль тогтоомжийн дагуу улсад гаргаж өгвөл зохих бүртгэл, тайлан, мэдээг гаргаж өгөөгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хугацаа хожимдуулсан, санаатайгаар буруу гаргасан бол 20000-50000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

46 дугаар зүйл. Хадлан тариалан, суулгац, тарьц устгах, гэмтээх

Бэлтгэсэн хадлан, тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан оруулан гишгүүлэх, идүүлэх зэргээр таримал, жимс жимсгэний болон бусад суулгац, тарьц устгасан, гэмтээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирлыг шүүхийн журмаар нөхөн төлүүлж 500-25000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

46¹ дүгээр зүйл. Ургамлын өвчин, хортонтой тэмцэх журам зөрчих

Ургамлын өвчин, хортонтой тэмцэх технологи зөрчсөн, түүнчлэн ургамлын өвчин, хортон устгах ажил гүйцэтгэсэн талбайд хорионы хугацаа дуусаагүй байхад аж ахуйн болон бусад үйл ажиллагаа явуулах зэргээр ургамал, хорио цээрийн дэглэм зөрчсөн бол зөрчил гаргасан иргэнийг 20000 хүртэл, албан тушаалтныг 40000 хүртэл, байгууллага, аж ахуйн нэгжийг 120000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

47 дугаар зүйл. Аюулгүй ажиллагааны журам зөрчих

1. Түлш, эрчим хүч үйлдвэрлэх, хэрэглэх, ашигт малтмалын хайгуул хийх, олборлолт явуулах, зуух, даралтат сав, өргөх, тээвэрлэх механизмыг ашиглах; уул уурхай, барилга болон тэсэрч дэлбэрэх аюул гарч болзошгүй бусад ажлыг гүйцэтгэх явцад техник ашиглалт, аюулгүй ажиллагааны журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчил гаргасан иргэнийг 1000-30000, албан тушаалтныг 3000-60000, байгууллага, аж ахуйн нэгжийг 80000-250000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

2. Тэсэрч дэлбэрэх болон радио идэвхит, түүнчлэн хүчтэй үйлчлэх болон хорт бодисыг бүртгэх, хадгалах, ашиглах, тээвэрлэх, илгээх, борлуулах, олж авах, бэлтгэх журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчил гаргасан иргэнийг 1000-25000, албан тушаалтныг 2000-40000, байгууллага, аж ахуйн нэгжийг 60000-200000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

50 дугаар зүйл. Эрчим хүч, холбоо ашиглах журам зөрчих

1. Цахилгаан болон дулааны эрчим хүч хууль бусаар ашигласан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хууль бусаар олсон орлогыг хурааж, зөрчил гаргасан иргэнийг 5000-50000, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-250000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

52 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж зөрчих

1. Зохих зөвшөөрөлгүйгээр эмчилгээ явуулсан, эмнэлгийн байгууллага байгуулж ажиллуулсан бол хууль бусаар олсон орлогыг хурааж, зөрчил гаргасан иргэнийг 20000 хүртэл, байгууллага, аж ахуйн нэгжийг 150000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

2. Эм биобэлдмэл үйлдвэрлэх, бэлтгэх, худалдаалах талаар тогтоосон журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хууль бусаар олсон орлого буюу эд зүйлийг хурааж, зөрчил гаргасан иргэнийг 25000 хүртэл, байгууллага, аж ахуйн нэгжийг 150000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

3. Хүний амь нас, эрүүл мэнд болон хүрээлэн буй орчинд хорт нөлөө үзүүлэх хими, биологи, физикийн хүчин зүйл, бодисыг зохих шинжилгээгүйгээр хэрэглэсэн, худалдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хууль бусаар олсон орлого буюу эд зүйлийг хурааж, зөрчил гаргасан иргэнийг 30000 хүртэл, байгууллага, аж ахуйн нэгжийг 150000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

4. Байгалийн болон гоц халдварт өвчин гарсан хориотой бүсэд нэвтрэх, ан агнах зэргээр хорио, цээрийн дэглэм зөрчсөн, байгалийн болон гоц халдварт өвчин үүсгэгч, нян тээгч зүйлсийг хот, суурин газар зохих шинжилгээгүй оруулсан, оруулахыг завдсан бол зөрчил гаргасан иргэнийг 35000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

5. Хог хаягдлаа ил асгах, орчин тойрноо бохирдуулах, ариун цэврийн шаардлага хангаагүй нөхцөлд худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах зэргээр ариун цэврийн талаар тогтоосон журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчил гаргасан иргэнийг 25000 хүртэл, байгууллага, аж ахуйн нэгжийг 150000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.